**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/229/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.24 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 13
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 17
**4.1 Ерөнхий зүйл** ..... 17
**4.2 Материаллаг байдал** ..... 17
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 17
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 17
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 18
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 18
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 18
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 19
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.19 № 2/06

танай____________-ны № ____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН УС,
ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА Ч.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Ус цаг уур, орчны шинжилгээний газраас ирсэн хөрөнгөөс 6,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг тусгай зориулалттай материалын дансанд бүртгэсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй.

5020065

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **340,089,002.20** | **369,478,664.68** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 20,000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 20,000.00 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 20,000.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 00.00 | 20,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 160,720.49 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 160,720.49 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 160,720.49 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 319,928,281.71 | 369,458,664.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 296,241,311.76 | 340,043,794.73 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 296,241,311.76 | 340,043,794.73 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,686,969.95 | 29,414,869.95 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 806,336.41 | 1,002,336.41 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,939,504.06 | 18,281,404.06 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,941,129.48 | 10,131,129.48 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 20,000,000.00 | 00.00 |
| 36600 | Бусад нөөц | 20,000,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **884,470,923.22** | **966,527,533.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 884,470,923.22 | 966,527,533.87 |
| **392** | **Биет хөрөнгө** | 658,076,839.86 | 740,156,367.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 639,997,043.28 | 657,061,103.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -57,475,606.49 | -64,524,548.26 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 78,608,973.78 | 83,608,973.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -45,786,222.40 | -46,567,716.48 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 284,559,471.52 | 255,042,286.55 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -247,576,788.34 | -148,383,890.08 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,507,750.00 | 15,507,750.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,757,781.49 | -11,587,592.02 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,280,000.00 | 6,280,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,280,000.00 | -6,280,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 226,394,083.36 | 226,371,166.72 |
| 39301 | Програм хангамж | 1,546,219.00 | 1,546,219.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,294,135.64 | -1,317,052.28 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 226,142,000.00 | 226,142,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,224,559,925.42** | **1,336,006,198.55** |
| **413** | **Өглөг** | 290,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,224,269,925.42** | **1,336,006,198.55** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,224,269,925.42 | 1,336,006,198.55 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 587,740,743.91 | 587,740,743.91 |
| 51101 | Өмч: - төрийн | 587,740,743.91 | 587,740,743.91 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 298,527,229.04 | 419,395,871.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 298,527,229.04 | 307,659,598.66 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 111,736,273.13 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 338,001,952.47 | 328,869,582.85 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,224,559,925.42** | **1,336,006,198.55** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,534,303,625.43** | **2,114,296,420.62** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **101,630,101.43** | **124,542,420.62** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 101,630,101.43 | 124,542,420.62 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 101,630,101.43 | 124,522,420.62 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000.00 | 200,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 101,430,101.43 | 124,322,420.62 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 20,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,432,673,524.00** | **1,989,754,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,385,461,100.00 | 1,988,296,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,385,461,100.00 | 1,988,296,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,212,424.00 | 1,457,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,004,424.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,760,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 448,000.00 | 1,457,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,457,698,053.27** | **2,002,560,147.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,457,698,053.27** | **2,002,560,147.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,352,841,555.65 | 1,925,575,033.10 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,108,185,163.90 | 1,623,444,592.31 |
| 210101 | Үндсэн цалин | 812,899,144.36 | 1,020,775,879.30 |
| 210102 | Нэмэгдэл | 265,098,918.64 | 327,672,947.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,187,100.90 | 148,200,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 126,795,765.35 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 137,470,813.34 | 204,459,253.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,172,623.32 | 142,363,064.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,294,666.34 | 16,267,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,248,275.66 | 13,013,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,986,084.99 | 3,109,122.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,769,163.03 | 29,705,967.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,113,224.88 | 45,670,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,391,734.88 | 5,921,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,589,690.00 | 39,388,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 131,800.00 | 360,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,854,112.26 | 24,699,582.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,029,800.00 | 1,622,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,826,146.00 | 9,019,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,150,467.27 | 3,761,230.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,884,270.00 | 4,089,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 375,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 17,963,428.99 | 5,832,852.60 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 390,400.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 390,400.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 53,100.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 53,100.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 977,200.00 | 1,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 977,200.00 | 1,896,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,576,644.50 | 6,914,930.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,027,508.50 | 4,687,570.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 233,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 798,584.00 | 435,592.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 77,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,517,552.00 | 1,406,768.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 308,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27,220,896.77 | 18,490,474.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1,267,476.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,220,896.77 | 17,222,998.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 104,856,497.62 | 76,985,114.39 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 86,633,611.00 | 75,054,200.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,954,316.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 81,679,295.00 | 75,054,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 18,222,886.62 | 1,930,914.39 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,222,886.62 | 1,930,914.39 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **76,605,572.16** | **111,736,273.13** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,432,873,524.00** | **1,989,974,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **200,000.00** | **220,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 200,000.00 | 220,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 200,000.00 | 200,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000.00 | 200,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 20,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,432,673,524.00** | **1,989,754,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,385,461,100.00 | 1,988,296,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,385,461,100.00 | 1,988,296,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,212,424.00 | 1,457,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,004,424.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,760,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 448,000.00 | 1,457,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,432,423,624.00** | **1,984,104,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,432,423,624.00** | **1,984,104,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,327,567,126.38** | **1,907,118,885.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,108,281,277.31 | 1,623,573,871.82 |
| 210101 | Үндсэн цалин | 812,995,257.77 | 1,017,935,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 265,098,919.54 | 323,225,371.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,187,100.00 | 148,200,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 134,213,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 137,752,596.42 | 204,459,253.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 95,102,368.35 | 141,273,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,364,921.31 | 16,267,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,248,257.66 | 13,013,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,986,044.99 | 3,253,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,051,004.11 | 30,651,353.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,982,599.00 | 50,060,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,756,609.00 | 5,921,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,094,190.00 | 43,778,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 131,800.00 | 360,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,436,262.27 | 14,986,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 460,000.00 | 1,479,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,486,775.00 | 9,019,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,431,987.27 | 3,874,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 57,500.00 | 614,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 390,400.00 | 191,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 390,400.00 | 191,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 380,700.00 | 4,109,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 330,000.00 | 259,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 50,700.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 3,850,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 977,200.00 | 1,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 977,200.00 | 1,896,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 54,366,091.38 | 7,841,660.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 52,838,592.38 | 5,614,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 233,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 590,584.00 | 435,592.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 77,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 703,915.00 | 1,406,768.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 308,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **104,856,497.62** | **76,985,114.39** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 86,633,611.00 | 75,054,200.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,954,316.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 81,679,295.00 | 75,054,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 18,222,886.62 | 1,930,914.39 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,222,886.62 | 1,930,914.39 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **449,900.00** | **5,870,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **449,900.00** | **5,850,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **449,900.00** | **5,850,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 449,900.00 | 5,850,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 449,900.00 | 5,850,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-449,900.00** | **-5,850,000.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 20,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 20,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 587,740,743.91 | 353,128,689.97 | 44,776,628.17 | 00.00 | 985,646,062.05 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 191,522.00 | 00.00 | 191,522.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **587,740,743.91** | **353,128,689.97** | **44,968,150.17** | **00.00** | 985,837,584.05 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 68,547,174.81 | 00.00 | 68,547,174.81 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **587,740,743.91** | **338,001,952.47** | **298,527,229.04** | **00.00** | 1,224,269,925.42 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **587,740,743.91** | **338,001,952.47** | **298,527,229.04** | **00.00** | 1,224,269,925.42 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 9,132,369.62 | 00.00 | 9,132,369.62 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **587,740,743.91** | **338,001,952.47** | **307,659,598.66** | **00.00** | 1,233,402,295.04 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -9,132,369.62 | 00.00 | 00.00 | -9,132,369.62 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 111,736,273.13 | 00.00 | 111,736,273.13 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **587,740,743.91** | **328,869,582.85** | **419,395,871.79** | **00.00** | 1,336,006,198.55 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,988,496,200.00 | 1,986,565,285.61 | 1,930,914.39 | 99.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,988,496,200.00 | 1,986,565,285.61 | 1,930,914.39 | 99.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,913,442,000.00 | 1,911,511,085.61 | 1,930,914.39 | 99.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,623,621,400.00 | 1,623,573,871.82 | 47,528.18 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 1,017,935,100.00 | 1,017,935,100.00 | 0.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 323,272,900.00 | 323,225,371.82 | 47,528.18 | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 148,200,000.00 | 148,200,000.00 | 0.00 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 134,213,400.00 | 134,213,400.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 206,342,600.00 | 204,459,253.79 | 1,883,346.21 | 99.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 141,273,200.00 | 141,273,200.00 | 0.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,267,300.00 | 16,267,300.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,013,800.00 | 13,013,800.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,253,600.00 | 3,253,600.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,534,700.00 | 30,651,353.79 | 1,883,346.21 | 94.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 50,060,200.00 | 50,060,200.00 | 0.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,921,700.00 | 5,921,700.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 43,778,500.00 | 43,778,500.00 | 0.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 360,000.00 | 360,000.00 | 0.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,986,700.00 | 14,986,700.00 | 0.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,479,000.00 | 1,479,000.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,019,100.00 | 9,019,100.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,874,200.00 | 3,874,200.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 614,400.00 | 614,400.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 191,300.00 | 191,300.00 | 0.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 191,300.00 | 191,300.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,959,900.00 | 4,959,900.00 | 0.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,109,900.00 | 1,109,900.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,850,000.00 | 3,850,000.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,896,000.00 | 1,896,000.00 | 0.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,896,000.00 | 1,896,000.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,383,900.00 | 11,383,860.00 | 40.00 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,156,500.00 | 9,156,500.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 435,600.00 | 435,592.00 | 8.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 77,000.00 | 0.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,406,800.00 | 1,406,768.00 | 32.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 308,000.00 | 308,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 75054200.00 | 75054200.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 75,054,200.00 | 75,054,200.00 | 0.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 75,054,200.00 | 75,054,200.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,988,496,200.00 | 1,986,565,285.61 | 1,930,914.39 | 99.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,988,296,200.00 | 1,986,365,285.61 | 1,930,914.39 | 99.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,988,296,200.00 | 1,986,365,285.61 | 1,930,914.39 | 99.9 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 90.00 | 90.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 83.00 | 83.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **90.00** | **90.00** | 0.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 90.00 | 90.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 47,212,424.00 | 1,457,800.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 47,212,424.00 | **1,457,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 47,212,424.00 | 1,457,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 47,212,424.00 | 1,457,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47,211,157.88 | 1,457,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,266.12 | 0.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,266.12 | 0.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 1457800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,212,424.00 | 1,457,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 47,212,424.00 | 1,457,800.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь цаг агаарын хувирал өөрчлөлтийг тасралтгүй ажиглан ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хангах, нийгэм эдийн засаг байгалийн болзошгүй аюулаас гарз хохиролгүй гаргах сэрэмжлүүлэх мэдээ боловсруулах үйл ажиллагаа явуулдаг байна.

Байгууллагын эрхэм зорилгоо “Аймаг орон нутгийн уур амьсгал түүний хувьсан өөрчлөгдөх зүй тогтол орчны бохирдолд байнгын хяналт шинжилгээ хийх, усны нөөц, цаг агаарын төлөв байдлыг урьдчилан тодорхойлох /прогнозлох/ шинжлэх ухаан техник технологийн дэвшилд тулгуурласан, мэргэжлийн инженер техникчтэйгээр орон тоогоо нэмэгдүүлсэн ус, цаг уур орчны шинжилгээний төвүүдийн түвшинд хүрэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх” гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Цаг уур орчны шинжилгээний газрын 2023 оны А/363 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Цаг уур орчны шинжилгээний төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 111,446.3 мянган төгрөг буюу 9.1 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|
| | ДҮН | ЭЗЛЭХ ХУВЬ | ДҮН | ЭЗЛЭХ ХУВЬ | ДҮН | ЭЗЛЭХ ХУВЬ |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 340,089.0 | 27.8 | 369,478.7 | 27.7 | 29,389.7 | 108.6 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - | 20.0 | 0.0 | 20.0 | #DIV/0! |
| АВЛАГА | 160.7 | 0.0 | - | - | (160.7) | - |
| УРЬДЧИЛГАА | - | - | - | - | - | #DIV/0! |
| БАРАА МАТЕРИАЛ | 319,928.3 | 26.1 | 369,458.7 | 27.7 | 49,530.4 | 115.5 |
| НӨӨЦИЙН БАРАА | 20,000.0 | 1.6 | - | - | (20,000.0) | - |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 884,470.9 | 72.2 | 966,527.5 | 72.3 | 82,056.6 | 109.3 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,252,641.5 | 102.3 | 1,245,188.3 | 93.2 | (7,453.1) | 99.4 |
| ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ | (368,170.5) | (30.1) | (278,660.8) | (20.9) | 89,509.7 | 75.7 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,224,559.9** | **100.0** | **1,336,006.2** | **100.0** | **111,446.3** | **109.1** |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 290.0 | 0.0 | - | - | (290.0) | - |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,224,269.9 | 100.0 | 1,336,006.2 | 100.0 | 111,736.3 | 109.1 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,224,559.9** | **100.0** | **1,336,006.2** | **100.0** | **111,446.3** | **109.1** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 20.0 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Авлагын данс эхний үлдэгдэл 160.7 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлын авлагатай байсныг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 369,458.7 мянган төгрөг болж өмнөх оноос 49,530.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 59,637.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Цаг уур орчны шинжилгээний газраас 46032.1 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж Архангай аймгийн УЦУОШГ-аас нэг бүр нь 486.0 мянган төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг Пуужин шилжүүлэн авсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,245,188.3 мянган төгрөг болж 7,453.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн худалдан авалтаар 5,850.0 мянга, Цаг уур орчны шинжилгээний газраас 11,954.9 төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоохтой холбоотой 81,876.6 мянган төгрөгөөр орлого авч 107,134.6 мянган төгрөгөөр данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,336,006.2 мянган төгрөг болж мянган төгрөг болж 111,736.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 111,736.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,569,262.8 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 125,312.5 мянган төгрөгөөр бууруулж 1,443,950.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,988,496.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,986,565.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,986,565.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь ЭМНДШ-ийн 1,888.3 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,913,442,000.00 | 1,911,511,085.61 | 1,930,914.39 | 99.9 |
| 2 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 75,054,200.00 | 75,054,200.00 | 0.00 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар давсан орлого 1,457.8 мянган төгрөг хуваарилсныг 800.0 мянган төгрөгийг түлш халаалтад, 446.1 мянган төгрөгийг цахилгааны төлбөрт, 211.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны эхэнд 15,778.5 мянган төгрөгийн халаалтын зардалтай байсан бөгөөд нүүрс худалдан авах шууд гэрээ байгуулсан ба 2023 оны 9 сараас 43,778.5 мянган төгрөг батлагдсанаас Скейл ХХК-тай  шууд гэрээ байгуулсан байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 43,778.5 мянга, гэрэл цахилгааны зардалд 5,921.7 мянга, цэвэр бохир усны зардалд 360.0 мянган төгрөг батлагдсанаас “Скейл” ХХК, Баянхонгор Эко дулаан ХХК-иудтай дулаанаар хангах, нүүрс нийлүүлэх гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-иудтай цахилгаанаар хангах гэрээ, тус тус байгуулж ажилласан байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 179 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 1,988,496.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,885.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,919.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 207,384.9 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж аудитаар 4,160.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 6,862.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 94 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 3 | 4,160.9 | 3 | 4,160.9 | 100% |
| Албан шаардлага | 2 | 6,862.0 | 2 | 6,862.0 | 100% |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100% |
| **Нийт дүн** | **6** | **11,022.9** | **6** | **11,022.9** | **100%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,500.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Ус цаг уур, орчны шинжилгээний газраас ирсэн хөрөнгөөс 6,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг тусгай зориулалттай материалын дансанд бүртгэсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар Шилэн дансны цахим хуудаст дутуу мэдээлсэн 207,384.0 мянган төгрөгийн төгрөгийн 1 зөрчил[2] илэрсэнд албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 6,500.0 мянган төгрөгийн алдаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 19,885.0 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 207,384.9 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг дутуу мэдээлсэн байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 207,384.9 мянган төгрөгийн 1 мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ус цаг уур, орчны шинжилгээний газраас ирсэн хөрөнгөөс 6,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг тусгай зориулалттай материалын дансанд бүртгэсэн | 1 | 6,500.0 | | | 1 | 6,500.0 | 1 | 6,500.0 | | |
| Дүн | **1** | **6,500.0** | | | **1** | **6,500.0** | **1** | **6,500.0** | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 207,384.9 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг дутуу мэдээлсэн. | 1 | 207,384.9 | | | 1 | 207,384.9 | | |
| Дүн | **1** | 207,384.9 | | | **1** | 207,384.9 | | |

------------oOo-------------